

**ЗАВХАН АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2021 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭ**

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

1.1.Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагааны талаарх мэдээлэл:

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлыг 1 удаа хийж, Улиастай сумын Өлзийт, Товцог, Богдын гол, Жаргалант багийн Засаг дарга нарыг үүрэгт ажлаас нь чөлөөлөхийг зөвшилцөх тухай, “Отгонтэнгэр” рашаан сувиллыг менежментийн гэрээгээр эзэмшүүлэх, үр дүнг харгалзан хувьчлах этгээдийг сонгон шалгаруулахтай холбоотой асуудлын талаар, Аймгийн “Хүндэт тэмдэг”-ийн загварыг өөрчлөх тухай, Аймгийн ГХУСАЗСЗ-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид, Ажлын албанаас 2021 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, Төрийн шагналд уламжлах тухай зэрэг асуудлуудыг хэлэлцэж шийдвэр гарган биелэлтийг хангуулахаар холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж ажиллаж байна.

Аймгийн ИТХ-ын 8 дахь удаагийн сонгуулиар байгуулагдсан Аймгийн ИТХурал бүрэн эрхээ хэрэгжүүлж эхэлсэнээсээ хойш 3 удаа хуралдаан хийж, анхдугаар хуралдаанаар Аймгийн ИТХ-ын 8 дахь удаагийн сонгуулийн дүн, аймгийн ИТХ-ын Төлөөлөгчдийн бүрэн эрхийг зөвшөөрөх тухай, Аймгийн ИТХ-ын хуралдааны дэг батлах тухай, Зохион байгуулалтын асуудлуудыг хэлэлцсэн бол Аймгийн ИТХ-ын 2, 3-р хуралдаанаар Аймгийн ИТХ-ын цахим хуралдааны дэг батлах тухай, Завхан аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг батлах тухай, Аймгийн 2021 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө батлах тухай, Аймгийн засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай, Аймгийн ИТХ-ын бодлогын хороодыг байгуулж, ажиллах чиглэлийг батлах тухай, Аймгийн орон нутгийн 2020 оны төсвийн хүлээгдэж буй гүйцэтгэл, 2021 оны төсөв батлах тухай, 2021 онд иргэдэд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтын саналыг Монгол улсын Засгийн газарт уламжлах тухай, Татварын давсан орлогыг хуваарилах, зарцуулах, зөвшөөрөл олгох тухай, Тогтоолд өөрчлөлт оруулах тухай асуудлуудыг хэлэлцэн 15 тогтоол гаргаж хэрэгжилтийг эхлүүлсэн байгаа.

1.2. Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаарх мэдээлэл:

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 216, 217, 218 дугаар тогтоолоор батлагдсан байгууллагын болон төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлагнах, үнэлэх журам, аргачлал батлагдсан журмыг хэрэгжилтийг хангах хүрээнд сургалтыг 2021 оны 01 сарын 12-15-ны өдрүүдэд аймгийн Засаг даргын Тамгын газраас сум, албан байгууллагын удирдлагууд,

холбогдох албан тушаалтнуудад сургалт зохион байгуулж, 350 гаруй албан тушаалтан хамрагдлаа.

Завхан аймгийн Засаг даргын зөвлөлийн хоёрдугаар хурал 2021 оны нэгдүгээр сарын 21-ний өдрийн 17:30 цагт эхэлж дараах 8 асуудлыг хэлэлцлээ. Үүнд:

“Аймгийн хошой аварга малчин өрх”, “Аймгийн аварга малчин өрх” шалгаруулах

“Аймгийн тэргүүний тариаланч” шалгаруулах

“Аймгийн алдарт уяач” тодруула

“Салбарын тэргүүний ажилтан” шалгаруулах

2020 оны жилийн эцсийн ажлын үзүүлэлт, үр дүнгээрээ тэргүүлсэн “Шилдэг агентлаг” тодруулах

2020 оны жилийн эцсийн ажлын үзүүлэлт, үр дүнгээрээ тэргүүлсэн “Шилдэг сум”, “Шилдэг баг” шалгаруулах

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц

Аймгийн аюулгүйн нөөцийн өвсний тухай асуудлыг тус тус хэлэлцэв.

“Аймгийн хошой аварга малчин өрх”-д Тэс сумын Дооно багийн малчин Ж.Дарамсэнгэ тэргүүлсэн бол “Аймгийн аварга малчин өрх”-өөр 24 сумын 60 малчин өрх шалгарлаа. “Аймгийн тэргүүний тариаланч”-аар Тэлмэн сумын Баянтэгш багийн тариаланч П.Тогтохбаяр, Улиастай сумын Жинст багийн тариаланч Д.Цэрэнбалжир нарыг, “Аймгийн алдарт уяач”-аар Улиастай сумын Богдын гол багийн уяач Ш.Баярмагнайг дэмжлээ.

Боловсрол, соёл, урлаг, биеийн тамир, спортын тэргүүний ажилтнаар Жавхлант цогцолбор сургуулийн багш Ц.Мөнхцэцэг, Түдэвтэй сумын Соёлын төвийн эрхлэгч Б.Отгонбаатар, Баруун бүсийн тамирчдыг олимпд бэлтгэх төвийн усанд сэлэлтийн дасгалжуулагч А.Пүрэвсүрэн, Улс төрийн албаны тэргүүний ажилтнаар Баянхайрхан сумын Засаг дарга Б.Батсайхан, Эрүүл мэндийн салбарын тэргүүний ажилтнаар аймгийн Нэгдсэн эмнэлгийн арга зүйч, сувилагч А.Амаржаргал, ХХАА, байгаль орчны салбарын тэргүүний ажилтнаар ХХААГ-ын Мал үржлийн албаны дарга Д.Бямбасүрэн, Төрийн жинхэнэ албаны тэргүүний ажилтнаар Нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагч Ц.Дүүрэнбилэг, Хууль, эрх зүй, хяналтын байгууллагын тэргүүний ажилтнаар Онцгой байдлын газрын хүний нөөц, бие бүрэлдэхүүний сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн, дэд хурандаа Б.Баттогтох, Үйлдвэрлэл, үйлчилгээ, авто тээвэр, барилгын салбарын тэргүүний ажилтнаар АУЭХС-ийн Ашиглалт засварын албаны дарга, цахилгаан шугам сүлжээний инженер Г.Нямдэмбэрэл, Хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарын тэргүүний ажилтнаар Идэр сумын

нийгмийн даатгалын байцаагч С.Өлзийжаргал, Татвар, санхүү, банк, статистикийн салбарын тэргүүний ажилтнаар аймгийн Статистикийн хэлстийн мэргэжилтэн Б.Энхмаа, Төрийн бус байгууллагын тэргүүний ажилтнаар Аймгийн ахмадын хорооны дарга Т.Пүрэвжаргал нарыг тус тус дэмжив.

“Шилдэг агентлаг”-аар Онцгой байдлын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Эрүүл мэндийн газар, “Шилдэг сум”-аар Тэлмэн сум, Эрдэнэхайрхан сум, Цагаанчулуут сум, “Шилдэг баг”-аар Эрдэнэхайрхан сумын Мөсөн баг, Баянхайрхан сумын Төөнт баг, Шилүүстэй сумын Чандмань баг шалгарав.

Аймгийн Засаг дарга Д.Түвшинжаргал Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын дарга, эрхлэгч нартай уулзаж аймгийн Засаг даргын дөрвөн жилийн үйл ажиллагааны хөтөлбөр, бодлого, шийдвэрийнхээ талаар мэдээлэл хийж, тодорхой үүрэг чиглэл өгч ажиллалаа. Уулзалтаар хэлтэс агентлагийн дарга нарт цаашид хэрэгжүүлэх бодлого, зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэдээлэл өгч, албан байгууллагын удирдлагууд аймгийн Засаг даргын дөрвөн жилийн үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд онцгой анхаарч ажиллах ёстойг хэллээ.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/448 тоот захирамжаар ажлын хэсэг байгуулан Согтууруулах ундаа, худалдаалах цэгийг стандартын дагуу болгох, цөөрүүлэх зорилгоор 24 сумын 341 архи, согтууруулах ундаа худалдаалах цэгт хяналт шалгалтыг хийлээ. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсийн дарга, мэргэжилтэн, аймгийн прокурорын газар, Мэргэжлийн хяналтын газар, аймгийн Цагдаагийн газрын холбогдох албан тушаалтнуудыг ажлын хамруулан 2021 оны 01 сарын 06-наас 18-ны хооронд зохион байгуулж, тайланг удирлагуудад танилцуулан холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд:

2.1. Төсвийн гүйцэтгэл: Аймгийн хэмжээгээр 2020 онд төсөвлөгдсөнөөр 100 тэрбум 902,1 сая төгрөг, зарлага 92 тэрбум 108,7 сая төгрөгт хүрсэн байна.

2.2.Татвар төлөлтийн байдал: Татварын орлогын төлөвлөгөө аймгийн дүнгээр 2020 онд улсын төсөвт орлогод 821.3 сая төгрөг төвлөрүүлэхээс 1,2 тэрбум төгрөг төвлөрүүлж, 395,3 сая төгрөгөөр буюу 148,1 хувиар, аймгийн төсвийн орлогод 7,2 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 8,4 тэрбум төгрөгийг төвлөрүүлж 1,1 тэрбум төгрөгөөр тус тус давуулан биелүүлснээр гүйцэтгэл 116.5 хувьтай байна. Сумын төсвийн орлогод 1,9 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 3,5 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, 1.6 тэрбум төгрөгөөр буюу 185,4 хувиар тус тус давуулан биелүүллээ. Улс, аймаг, сумын төсвийн орлогын төлөвлөгөөг сар бүр өссөн дүнгээр жигд ханган биелүүлсэн үзүүлэлттэй байна.

Гурав. Хууль зүйн бодлогын хүрээнд:

3.1. Хууль хяналтын үйл ажиллагаа: 2021 оны 01 дүгээр сарын байдлаар Засаг даргын үйл ажиллагааны-25, Боловсон хүчний захирамж-5 гарсан байна. Тухайлбал: Комисс томилох тухай, Хөрөнгө гаргах тухай, Ажлын хэсэг байгуулах тухай, Захирамж хүчингүй болгох тухай, Үнэлгээний хороо байгуулах тухай, Иргэнд газар өмчлүүлэх тухай, Эрх сэргээх тухай, Зөрчил арилгуулж захирамж хүчингүй болгох тухай, Ажлаас чөлөөлөх тухай, Ажилд томилох тухай, газар эзэмших эрх шилжүүлэх тухай, эзэмших, өмчлөх эрх олгох тухай, Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай, Урамшуулал олгох тухай, Эрх шилжүүлэн гүйцэтгүүлэх тухай гэх мэт захирамж гаргасан.

Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын цагдаагийн хэлтэс, сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтарч ойгоос хууль бусаар мод бэлтгэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, Тосонцэнгэл, Тэлмэн сумдын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа "Ойн мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх зорилгоор " Хөрөө рам-хяналт шалгалт-2021 " хэсэгчилсэн арга хэмжээг 2021 оны 01 сарын 11-ний өдрөөс эхлэн зохион байгуулан ажиллаж байна.

Гудамж талбайд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, хяналтын камерын тоо, чанарыг нэмэгдүүлэх зорилгоор тус цагдаагийн газраас "ТЕЛЕ ХЯНАЛТЫН КАМЕР-2021" хэсэгчилсэн арга хэмжээг нэгдүгээр сарын 05-аас зохион байгуулж, сумдын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил зохицуулах салбар зөвлөл, байгууллага, аж ахуй нэгжүүдэд мэдэгдэл шаардлага хүргүүлээ.

Тус арга хэмжээг Цагаанхайрхан, Цагаанчулуут сумд үр дүнтэй зохион байгуулж сумын төвийн нийтийн эзэмшлийн гудамж талбайд чигийн болон, 360 градус эргэдэг хөдөлгөөнт хяналтын камер суурилуулж, төрийн байгууллага, аж ахуй нэгжүүд, байгууллагын орчныг хянах сүүлийн үеийн стандартын шаардлага хангасан иж бүрэн хяналтын камертай боллоо.

3.2. Гэмт хэрэг, зөрчлийн талаархи мэдээлэл: Тус цагдаагийн газарт 2021 оны эхний нэгдүгээр сард иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас 100 гомдол, мэдээлэл хүлээн авч 60 гомдол, мэдээллийг шалгаж шийдвэрлэсэн байна. Одоо ажиллагаанд үлдэгдэл 40 гомдол, мэдээлэл байна. Бүртгэгдсэн гомдол, мэдээллийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал 8 нэгжээр буюу 8.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Нийт бүртгэгдсэн 100 гомдол, мэдээллийн 52 буюу 52.0 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 48 буюу 48.0 хувь нь зөрчлийн шинжтэй байна.

2021 оны 01 дүгээр сард нийт 15 гэмт хэрэг статистик мэдээгээр тоологдсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 11 хэргээр буюу 42.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Бүртгэгдсэн гэмт хэрэг /хэргийн ангиллаар/:

Нийт гэмт хэргийн 12 буюу 80 хувийг хөнгөн, 3 буюу 20.0 хувийг хүнд гэмт хэрэг эзлэж байна. Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал хөнгөн хэрэг 5 хэргээр буюу 29.4 хувиар буурсан, хүнд хэрэг 6 хэргээр буюу 66.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

2021 оны эхний 01 сарын байдлаар нийт 953 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 97 зөрчлөөр буюу 10.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Нийт бүртгэгдсэн 953 зөрчлийн 909 хүн, 1 хуулийн этгээдэд 33.537.000 төгрөгөөр торгох шийтгэл, 21 иргэнийг торгох+эрх хасах шийтгэл, 13 иргэнийг баривчлах шийтгэл оногдуулж, одоо ажиллагаанд шийдвэрлээгүй 13 зөрчил үлдсэн байна.

3.3. Архивын ажлын мэдээлэл: Төрийн архивын баримтыг мэдээллийн технологит шилжүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд: 147,196,167,139 дүгээр хөмрөг буюу 4 хөмрөг, 4 данс, 84 хадгаламжийн нэгжийн 5787 хуудас баримтыг сканердаж, 4 хөмрөг 4 дансны 84 хадгаламжийн нэгж, 5787 хуудас баримтыг photoshop програмд засварлаж, 1 хөмрөг, 2 дансны 25 хадгаламжийн нэгж, 2769 хуудас баримтаас заалт 2741, хүний нэр 12518, газарзүйн нэр 1541 цахим хэлбэрт оруулж, 25 PDF холболт хийлээ.

2 хөмрөгийн 32 хадгаламжийн нэгж баримтанд иж бүрэн нягтлан шалгалт хийж, үдэж хавтаслан холбогдох акт үйлдэж, данс бүртгэлд оруулсан.

Давхардсан тоогоор 235 иргэн, 18 байгууллагын хүсэлтийг хүлээн авч 807 баримт шүүж, 222 хуулбар, 237 лавлагаа, тодорхойлолт олгож төрийн үйлчилгээ үзүүллээ.

Хөмрөг үүсгэгч 195 байгууллагын нэгдсэн тоо бүртгэлийн мэдээ авч, 66 хөмрөг үүсгэгчийн мэдээг программд шивж орууллаа.

Архив, бичиг хэргийн ажилтнуудаас 2020 онд Архивын ерөнхий газрын анхан болон мэргэшүүлэх сургалтанд хамрагдах ажилтнуудын судалгааг авч нэгтгэн Архивын ерөнхий газарт хүргүүллээ.

Төрийн архивын баримтыг 2021 онд мэдээллийн технологит шилжүүлэх ажлын судалгаа гаргаж, төлөвлөгөөг батлан ажиллаж эхэлсэн.

2021 оны 1 дүгээр сард мэдээллийн технологит шилжүүлсэн ажлын мэдээг гаргаж Архивын ерөнхий газарт хүргүүллээ. Аймгийн Засаг даргын дэргэдэх 6 хэлтэс агентлагийн архив, албан хэрэг хөтлөлтийн ажилд хяналт шинжилгээ үнэлгээ хийж мэргэжил арга зүйн зөвлөгөө заавар өгсөн.

E-archives үйлчилгээний нэгдсэн системийг ашиглан Үндэсний төв архиваас лавлагаа авах хүсэлтийг илгээж, 7 иргэний лавлагааг шийдвэрлэн олголоо, мөн үйлчилгээний нэгдсэн системийг ашиглаж, цахим гарын үсэг ашиглах гэрээ байгуулан холбогдох тоног төхөөрмжийг суурилуулах ажлыг эхлүүлсэн.

4 хөмрөг үүсгэгчээс 987 хадгаламжийн нэгж баримтыг хүлээн авч Төрийн архивын сан хөмрөгт баяжилт хийлээ.

3.4.Онцгой байдал: Аймгийн Онцгой комиссын хурлыг сум орон нутгийн өвөлжилтийн нөхцөл байдалтай холбогдуулан 1 удаа хуралдуулж холбогдох шийдвэрүүдийг гаргуулан хэрэгжүүлэн ажиллах талаар байгууллагын дарга нарт үүрэг чиглэл өгч ажиллаа.

2021 оны 01 дүгээр сард Онцгой комисс коронавируст халдвар (COVID-19), өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, сум орон нутгийн өвөлжилтийн нөхцөл байдалтай холбогдуулан 1 удаа хуралдаж, 3 шийдвэр гарган холбогдох арга хэмжээнүүдийг авч ажиллаж байна.

Аймгийн шуурхай штаб 2021 оны 01 дүгээр сард 5 удаа хуралдаж 27 шийдвэрийг гарган холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.

Тус хугацаанд Улаанбаатар хотоос аймгийн харьяал бүхий иргэдийг 01 дүгээр сарын 19-25-ний өдрүүдэд тус тус татан авах арга хэмжээг зохион байгуулсан.

Гэрийн тусгаарлан ажиглалтад 01 дүгээр сарын 25-ний өдрийн байдлаар 913 иргэн хянагдаж байна.

Түргэвчилсэн оношлуураар нийт өссөн дүнгээр 1694 хүн шинжилгээнд хамрагдаж шинжилгээний хариу сөрөг гарсан.

Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах чиглэлээр Онцгой байдлын газрын даргын 2020 оны А/20 дугаар "Хяналтын цэгийн постод үүрэг гүйцэтгэх алба хаагчдыг томилох тухай" тушаалын хэрэгжилтийг хангаж 4 хэсэг 25 зүйл заалт бүхий Сум орон нутгийн хяналтын цэгийн постод үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын гүйцэтгэх үүргийг гаргаж алба хаагчдад танилцуулан мэргэжил арга зүйн заавар зөвлөмж өгч хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна.

Шинэ төрлийн коронавирүсийн халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр алба хаагчдад сургалт зохион байгуулж өглөө бүр алба хаагч болон байгууллагаар үйлчлүүлж байгаа иргэдийн биеийн дулааныг хэмжиж, гарыг нь ариутган өрөө тасалгаануудыг жавилоны уусмалаар ариутгал халдваргүйжүүлэлт хийж урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч байна.

Улиастай, Тосонцэнгэл, Тэс сум дахь Гал түймэр унтраах, аврах ангийн алба хаагчид тус сумдын нутаг дэвсгэрт чанга яригч ашиглан коронавирүсийн халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр Эрүүл мэндийн яам, Улсын онцгой комисс, аймаг

орон нутгийн мэргэжлийн байгууллагаас гаргасан заавар, зөвлөмж сэрэмжлүүлэг мэдээг тус тус хүргэсэн.

Энэ сард Төлөвлөгөөт бус хяналт шалгалтаар 10 байгууллага аж ахуйн нэгжийг хамруулах хяналт шалгалтыг зохион явууллаа.

Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтаар Гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг зайлшгүй байх шаардлага норм, нормативын дагуу байрлуулаагүй, ажилчдад гамшгаас хамгаалах, гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт, дадлага зохион байгуулаагүй, гал унтраагуулууд цэнэг дууссан, авралтын зам гарцын схем зураг, галын аюулаас урьдчилан сэргийлэх самбар, санамжийг байрлуулаагүй, аваарын гэрэлтүүлэг суурилуулаагүй зэрэг зөрчил дутагдалууд илэрлээ.

Хяналт шалгалтын хүрээнд илэрсэн зөрчил дутагдлуудыг арилгуулахаар байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 4, мэдэгдэл 2 хүргүүлж, шалгалтын дүнгийн талаар шалгалтад хамрагдсан газрын удирдлагууд болон ажилчдад танилцуулж, Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай хуулиудад заагдсан эрх үүрэг, илэрч байгаа зөрчлүүдийг арилгах талаар нийт 15 хүнд мэргэжил арга зүйн зөвлөмж өгч ажиллалаа.

Урьдчилан сэргийлэх чиглэлээр Засгийн газрын шийдвэрээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хэрэглэсэн эрчим хүчний үнийг төрөөс хариуцах болсонтой холбоотойгоор иргэдийн эрчим хүчний зохисгүй хэрэглээнээс хэт ачаалал үүсч эрчим хүчний агаарын болон газар доорх шугам сүлжээ дэд станц болон төвлөрсөн станцуудад эвдрэл гэмтэл гарч тодорхойгүй хугацаагаар эрчим хүч тасалдаж аж ахуйн нэгж, байгууллага, айл өрхөд хөлдөлт үүсэх, гал түймэр гарч ихээхэн хэмжээний хохирол, хор уршиг гарч болзошгүй нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулж сэрэмжлүүлэг мэдээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр ард иргэдэд хүргүүлсэн.

Монгол Улсын Шадар сайдын баталсан “Эрчим хүч, ус дулаан хангамжийн салбарын тогтвортой ажиллагааг аж ахуйн нэгж байгууллага, айл өрхийн гал түймрийн аюулгүй байдлыг хангуулах нэгдсэн арга хэмжээ”-ний удирдамжийн дагуу Тэс, Тосонцэнгэл, Улиастай сумдын 4 багийн гэр хорооллын 580 өрх айлаар орж нийт 220 зөрчлийг илрүүлж 60 зөрчлийг арилгуулж, нийт 1700 хүнд мэргэжил арга зүйн зөвлөмж өгч, 340 ширхэг санамж бичиг тараан, 2 иргэнд нийт 200.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажиллалаа.

Баян-Айраг ХХК-ний Дөрвөлжин суманд байрлах алт, мөнгөний үндсэн ордыг олборлох, боловсруулах үйлдвэр, Түүчээ тэрэг ХХК-ий Ургамал суманд байрлах алтны ил уурхайд хийгдсэн гамшгийн эрсдэлийн үнэлгээний тайланд анхан шатны хяналт хийлээ.

Дөрөв. Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

4.1. Боловсрол, соёлын чиглэлээр: STEM боловсролын хэрэгжилтийн үр дүн, ач холбогдлыг таниулсан 2 удаагийн бичлэгийг Улиастай сумын Дэвшил сургуулийг түшиглэн Завхан телевизтэй хамтран хийж БМДИ-д хүргэлээ.

Тусгай хэрэгцээ тодруулах үнэлгээний асуумжийг 30 эцэг эх, дунд ангийн 20 суралцагчаас авч нэгтгэн БШУЯ-д хүргүүлэн ажиллалаа. Судалгаанаас харахад тусгай хэрэгцээт боловсролтой хүүхдүүдэд интэрнэт орчин бүрдээгүй, гэртээ зурагт байхгүй, ойлгодоггүй учраас теле хичээл үздэггүй цаашид хичээлийн сурах бичиг, хүүхдийн унших ном, гар утас, интернэт орчинд суурилсан интерактив хичээлийн агуулга, хэрэгсэл, оюун ухаан хөгжүүлэх тоглоом, биеийн тамир, спортын хэрэгсэл шаардлагатай, эцэг эхчүүд өрхийн орлого багаснаас болж хүүхдийнхээ суурь хэрэгцээг хангаж чадахгүй байх, хүүхдийн хичээл тасалдаж сурлагын хоцрогдол үүсэх, хүүхдийн хичээл, сурах үйл ажиллагаанд тааламжтай орчин гэртээ бүрдүүлж чадахгүй байх, хүүхдийнхээ хичээл сурлагад хэрхэн туслахаа мэдэхгүй байх зэрэг хүмүүжлийн талаар илүү санаа зовж байна гэсэн хариулт өгсөн байна.

STEM боловсролын хэрэгжилтийг улсад түгээн дэлгэрүүлэх зорилгоор Улиастай сумын Дэвшил сургуулийг түшиглэн 2 удаагийн бичлэгийг Завхан телевизтэй хамтран хийж Багшийн мэргэжил дээшлүүлэх институтэд хүргэн ажиллалаа. Тус бичлэгт STEM боловсрол хэрэгжиж эхэлснээс хойш 4 жилийн хугацаанд Завхан аймаг ямар ажил зохион байгуулсан, хүүхдэд ямар өөрчлөлт үр дүн гарсныг харуулахыг зорилоо.

2021 оны 1-р улирлын эхний долоо хоногийн “Томуу, томуу төст өвчний тархалтын тандалт судалгаа”-г ЭМГ-ын Халдварт өвчин, эмнэлгийн дотоод халдвар хариуцсан мэргэжилтнээс авч нэгтгэн БШУ-ын яаманд хүргүүллээ. Судалгаагаар томуу, томуу төст өвчний амбулаторийн үзлэгт 2-5 нас-9, 6-10 нас-5, 11-14 нас-3, 15-17 нас-1 нийт 18 хүүхэд хамрагдаж, амбулаторийн үзлэгийн хувь 0.95% байна.

Теле хичээл үзэж чадахгүй байгаа суралцагчдын нэгдсэн судалгааг ерөнхий боловсролын 29 сургууль, 39 цэцэрлэгээс авч нэгтгэл хийж БШУ-ын яаманд хүргүүллээ. Судалгаагаар теле хичээл үзэж чадаагүй цэцэрлэгийн 1235 хүүхэд, бага ангийн 1632, дунд ангийн 1772, ахлах ангийн 783 нийт 4217 хүүхэд теле хичээлээ үзэж чадаагүй байна.

Ерөнхий боловсролын 23 сургуулиас 10 судлагдахуунаар ЭЕШ өгөх суралцагчдын судалгааг авч, танхимын давтлага хичээллэх үед баримтлах журам, хичээллэх хүсэлтийн хамт аймгийн онцгой комисст хүргүүлж, 2021.01.25-наас хичээллэж эхэлсэн ба судлагдахуун хариуцсан мэргэжилтнүүд суралцагчдад танхимын хичээл зохион байгуулах багш нарт мэргэжлийн бүлгээр хамтран ажиллах ажлын чиглэл, хуваарийг хүргэн ажиллалаа.

Багшийн мэргэжил дээшлүүлэх институтээс зохион байгуулдаг үндсэн сургалтанд хамрагдах багш нарын судалгааг шинэчилж, эхний болон 5 дахь жилдээ ажиллаж буй 46 багшийн судалгаа, нэрсийг гаргаж хүргүүллээ.

Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч, Ерөнхий боловсролын сургуулийн захирал, сумдын соёлын төвийн дарга нарын 2020 оны гүйцэтгэлийн төлвөлгөөний хэрэгжилтийг хуваарийн дагуу сонсож, хэлэлцлээ.

Коронавируст цар тахлын улмаас өндөржүүлсэн бэлэн байдал зарлаж, танхимын хичээл, сургалтын үйл ажиллагааг цахимд шилжүүлсэнтэй холбогдуулан дараах үйл ажиллагааг цахимаар зохион байгууллаа.

“Мэдлэгээ хэрэглээ болгоцгооё” цахим аяны удирдамжийг боловсруулан ерөнхий боловсролын 29 сургуульд хүргэн ажиллалаа. Тус аянаар бага боловсролын багш нар суралцагчдын сурлагын хоцрогдлыг арилгах зорилгоор хэрэглээний сонирхолтой даалгавар боловсруулан хүүхэд бүртээ хүргэж, эцэг эхдээ заавар зөвлөмж өгч ажиллаж байна. Ингэснээр хүүхдийн хичээл хийх сонирхол нэмэгдэж байна. Аяны хүрээнд бага боловсролын багш нартай онлайн хэлэлцүүлгийг 2021 оны 01 дүгээр сарын 15, 22-ны өдрүүдэд тус тус зохион байгуулж аяны үр дүн цаашид анхаарах зүйлийн талаар санал солилцож хамтран туршлага судалж байна.

“Аавдаа би хайртай”, “Ээж тандаа баярлалаа” гар зураг, захидлын уралдааны удирдамжийг боловсруулан ерөнхий боловсролын 29 сургуульд хүргэн ажиллалаа.

Бага боловсролын багш нарын бичих чадварыг дээшлүүлэх зорилгоор мод тарьцгаая, баярлаж явдаг дотны хүндээ талархсан захидал, миний хийх дуртай зүйл, миний хайртай амьтан сэдэвт 120-150 үгтэй зохион бичлэг бичих даалгаврыг өгч, уншиж танилцан зөвлөмж хүргүүлэн, өгүүлбэртэй бодлого бодох чадварыг нэмэгдүүлэх зорилгоор 7 хоног бүр Д.Бүндэнгийн сургалтын материалаас 10 бодлого бодуулан, бодох аргыг тайлбарлан онолын мэдлэгийг нэмэгдүүлэн ажиллаж байна.

Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хөгжмийн боловсролын багш нарын дунд хөгжмийн цахим хичээлийн уралдааныг зарлан дүгнэж байна.

“Монгол Улсын Зэвсэгт хүчин 100” гар зургийн уралдаан зохион байгуулах удирдамжийг ЕБС-н 29 сургууль, мэргэжлийн багш нарт хүргүүллээ. Уралдаан 2021 оны 01 сарын 18-наас 03 сарын 05 хүртэл 2 үе шаттай явагдана.

Аймгийн тахилга шүтлэгт 111 уул овоо, газар усны тухай мэдээллийг тахилга шүтлэгт уул усны нэгдсэн бүртгэлийн www.tahilga.mongoluv.mn сайтад шивж орууллаа.

Очирваань хайрханы тахилгын талаар мэдээллийг бэлтгэж, Монголын тахилгатай уул овооны тухай номонд оруулахаар Байгаль соёлын өвийг хамгаалах санд хүргүүллээ.

4.2.Эрүүл мэнд, спортын чиглэлээр: 2021 оны 1 дүгээр сард аймгийн хэмжээнд нийт 1720 иргэн нэвтэрснийг бүртгэлжүүлэн, асуумж судалгаа авч, Монгол Улсын шадар сайд, Онцгой комиссын даргын 2020 оны 03 дугаар сарын 14- ны өдрийн "Коронавируст халдар (COVID-19)-ын үед иргэнийг тусгаарлах, ажиглах түр журам", Эрүүл мэндийн сайдын А/269 дугаар тушаалын дагуу гэрийн тусгаарлан ажиглалтад 1512 иргэнийг шилжүүлэн, ачаа тээврийн 54 жолоочид халдвар хамгааллын дэглэм баримтлах талаар зөвлөмж мэдээлэл өгч, аймгийн Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газартай хамтран өдөр бүр хяналт тавин ажиллаж байна.

Эрүүл мэндийн байгууллагыг бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” ЭМС-ын 2021 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/04 тушаалын хэрэгжилтийн ханган, 7 хоног бүрийн Пүрэв гаригт ЭМЯ-ны Эмнэлгийн тусламжийн газарт мэдээг хүргүүлэн ажиллаж байна.

Эрүүл мэндийн газраас аймгийн Нэгдсэн эмнэлэгт ажлын байрны “КОВИД-19” өвчний халдварт өртөх байдлын эрсдэлийн үнэлгээг хийж, эрсдэлийн түвшин “**Өндөр**” үнэлэгдэж, үнэлгээний дагуу зөвлөмжийг хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Коронавируст халдвартай тэмцэх, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхижуулах, халдвараас сэргийлэх цахим сургалтад 23 сумын 126 эмч эмнэлгийн мэргэжилтэнг, хамгаалах хувцас хэрэгсэл өмсөж, тайлах дадлага сургалтыг эрүүл мэндийн байгууллагуудад өдөрт 2 удаа тогтмол хийж байна.

Аймгийн хэмжээний 3-5 хүртэлхх насны хүүхдүүдийн суурь судалгааг гарган, тарьдаг саагийн нөхөн дархлаажуулалт хийх ажлыг харьяа эрүүл мэндийн байгууллагуудад зохион байгуулан, нөхөн дархлаажуулалт 86%-тай хийгдэж байна. Улсын онцгой комисс, Эрүүл мэндийн сайдын албан даалгаврын дагуу **COVID-19** дархлаажуулалт хийх бэлэн байдлыг ханган ажиллаж байна

Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд: Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний салбарт гарсан 3 үндэсний хөтөлбөрийн тайлан мэдээг гаргаж Жижиг, дунд үйлдвэрийн газарт хүргүүлээ.

Хоршооны хуулийн шинэчилсэн найруулгын онлайн хэлэлцүүлгийг 2021 оны 01-р сарын 21-ны өдөр Жижиг, дунд үйлдвэрийн газар, ХААХНХолбоотой хамтран зохион байгууллаа. Уг хэлэлцүүлэгт манай аймгийн 5 сумын 7 хоршооны төлөөлөл нийт 56 хүн хамрагдсан байна.

Жижиг, дунд үйлдвэрийн газраас 2021 оны 01-р сарын 25-ны өдөр сум хөгжүүлэх сангийн уулзалт хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Уг сургалтаар сум

хөгжүүлэх санд хийж хэрэгжүүлсэн ажил, тус сангийн программын үйл ажиллагаа, цаашид авах арга хэмжээ, анхаарах асуудлууд, Монгол банкны мэдээллийн санд хэрхэн орох талаар явагдлаа.

Аймгийн хэмжээнд согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй 2 үйлдвэрийн хүнсний зориулалтаар ашиглах 23200 литр спиртийн захиалгыг ХХААХҮЯ-ны хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт хүргүүллээ. Үүнд: Завхан Баялаг ХК 21000 литр, Мөнхөд Мандаг ХХК 2200 литр захиалга өгсөн байна.

Сумдаас хүнсний нөөцийг мэдээг сумдаас долоо хоног бүрийн даваа, пүрэв гарагуудад авч нэгтгэн ХХААХҮЯ-ам, аймгийн ЗДТГазарт хүргүүлж байна. Аймгийн хэмжээнд мах 135.3 тн, гурил 293.0 тн, гурилан бүтээгдэхүүн 10.4 тн, будаа 48.3 тн, ургамлын тос 7.7 тн, төмс 650.9 тн, хүнсний ногоо 495.4 тн, элсэн чихэр 31.4, давс 18.6, цэвэр ус 15.3 тн нөөцтэй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 394 дугаар тогтоолын дагуу 2020-2021 онд 16 сумын арьс, шир бэлтгэж үндэсний үйлдвэрт тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдийн давхардсан тоогоор 5058 өрхийн нийт-158.977 ширхэг буюу хонь-117.303, ямаа-30.599, үхэр-10.240, адуу-835 арьс, ширний мэдээллийг программд тулгалт хийн тайланг хүргүүллээ.

Арьс, ширний урамшуулал олгох “Засгийн Газрын 2013 оны 394 дүгээр тогтоол”, хонь, тэмээний ноос бэлтгэж, үндэсний үйлдвэрт тушаасан малчин, мал бүхий этгээдийн мөнгөн урамшуулал олгох “2019 оны 343-р тогтоол”-ыг хэрэгжүүлэн мөн “2020 онд Засгийн Газрын 101 тогтоол”-ын дагуу нэг ямаанаас - 0,3 кг гарахаар бодож, 1кг тутамд 20.000 төгрөгийг олгосон талаарх мэдээ мэдээлэл, цаашид малчин, мал бүхий этгээдийн алдаа дутагдлыг залруулж сум орон нутагтаа журмаа мөрдөн ажиллах албан тоот сумдын Засаг дарга нарт хүргүүлсэн.

Мал, амьтны халвдарт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд Биокомбинат улсын төсөвт үйлдвэрийн газраас Шөвөг ярын вакцин 270 тн тун, шөвөг ярын шингэлэгч 2,7 литр, Дотрын халдварт хордлогын 1581,2 литр шингэлэгч 1000 литрыг хүлээн авсан байна.

Халдварт болон шимэгчтэх, ариутгал халдваргүйтгэлийн 2021 оны сумдын хувиарыг хийж Мал эмнэлгийн газрын даргаар батлуулж ажиллаа.

Мал эмнэлгийн лаборатори нь 17025:2018 чадавхийн итгэмжлэл авах ажлын хүрээнд чанарын гарын авлага холбогдох журмуудыг хийж ажиллаж байна.

Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд:

6.1. Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр: Тэлмэн сум өвөгдий багийн нутаг дэвсгэрт хөрөө рам ажиллуулахаар Ар Ангирт ХХК нь байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргуулахаар хүсэлт өгсөний дагуу уг төслийг судлаж байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлтийг гаргаж зөвлөмж өгч ажиллалаа.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2020 оны 12 дугаар 18-ны өдрийн 06 дугаар албан даалгавар буюу "Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зэрлэг амьтдад биотехникийн арга хэмжээ авах, мал амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх" чиглэл ирсэнтэй холбогдуулан Завхан аймгийн МХГ, МЭГ, БОАЖГ, Хомын талын тахь ТББ хамтран аймгийн Засаг даргын орлогчоор төлөвлөгөө батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Тус төлөвлөгөөнд:

- Сум бүр 1-2 удаа биотехникийн арга хэмжээ авах.
- Мал амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхээр тусгагдсан бөгөөд завхан аймгийн нэгдэсэн групп, 24 сумын цахим сүлжээнд бог малын мялзан өвчний танилцуулга бэлтгэн сурталчилаад байна.

Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан 4.0 сая төгрөгөөр биотехникийн арга хэмжээг 2021 оны 1 сарын 5-25-ны өдрүүдэд дараах сумдад авч ажиллалаа. Завхан аймгийн Цагаанчулуут сумын баруун туулайтад 10 боодол өвс 2 уут хужир, Шилүүстэй сумын алаг цахирт 20 боодол өвс, Отгон сумын бор хавцалд 15 боодол өвс 3 уут хужир, Алдархаан сумын хаалгын аманд 10 боодол өвс Яруу сумын Мандал ууланд 15 боодол өвс, 3 уут хужир, Тосонцэнгэл сумын Рашаант багийн Бумбат, Баян-Улаан багийн Чаргатад 18 боодол өвс, 10 уут хужир, Их-Уул сумын Зарт багийн Халуун усны Цуухайн эхэд 5 боодол өвс, 3 уут хужир Тэлмэн сумын Баян тэгш багийн Ар эрээн гэдэг газар 8 боодол өвс, 4 уут хужир биотехникийн арга хэмжээ авсан. Аймгийн хэмжээнд нийт 81 боодол өвс, 25 уут хужир тавьсан байна.

Мөн Идэр, Түдэвтэй, Сонгино, Яруу, Отгон, сумд сумын төсвөөс биотехникийн арга хэмжээ авч ажилласан байна.

НҮБ-ийн хүүхдийн сангийн төсөл, МНААҮХолбооны сургагч багш нартай хамтран Хүн амын ундны ус, ариун цэврийн байгууламжийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр хийгдсэн туршлагыг нэвтэрүүлэх зорилгоор "Завхан аймгийн сумдын хүн амын ундны ус, ариун цэврийн байгууламжийн аюулгүй байдлын төлөвлөгөөг сайжруулах" сэдэвт сургалтанд ахлах мэргэжилтэн, усны мэргэжилтнүүд нар хамрагдлаа.

Тус сургалтанд Асгат, Баянхайрхан, Тэс, Баянтэс, Улиастай Аймгийн ундны усны аюулгүй байдлын баг хамтарсан 40 хүний бүрэлдэхүүнтэй хамрагдлаа.

Сургалтаар сумдын ундны усны аюулгүй байдлын баг бүрдүүлэх, төлөвлөгөө боловсруулж үе шаттай хэрэгжүүлэх талаар мэдлэгийг олгосон үр дүнтэй сургалт болсон.

6.2. Дэд бүтцийн чиглэлээр: Хаягжуулалтын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан хаягжуулалтын журам, Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 15 дугаар тушаалаар батлагдсан “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журмын хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Энэ ажлын хүрээнд 2013-2017 онуудад хийгдсэн хаягийн зураг, хаягийн мэдээллийн санг шинэчлэгдсэн журамд нийцүүлэн бүрдүүлэх шаардлагатай байгаа бөгөөд хаягийн мэдээллийн систем бий болсноор төрийн болон бусад байгууллага, иргэдийг байршилд суурилсан хаягийн баталгаажсан мэдээллээр хангах, төрийн үйлчилгээг орчин үеийн шаардлагад нийцүүлэн хүргэх чухал үүрэг гүйцэтгэх, цаашид хаягийн мэдээллийг замчлах системд оруулан ашиглаж яаралтай тусламж, онцгой байдал, аюул ослоос хамгаалах, урьдчилан сэргийлэх зэрэг үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, үнэн зөв мэдээллээр хангах тогтолцоо бүрдэх юм.

Хаягийн зураг, мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг 2017 онд хүлээн авснаас хойш сумдууд хаягийн зураг, мэдээллийн сангийн шинэчлэлт дутуу хийгдэх, тусгай барилга, байгууламжууд үсгэн болон тоон тэмдэглэгээгээр хаяглагдаагүй, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор батлагдаагүй гудамжны нэр, дугаарыг хаягийн зурагт оруулсан, орон нутгийн сонгуулийн дараа гудамжны нэрийг өөрчлөх тохиолдол гарсан бөгөөд зохих өөрчлөлтийг тухай бүр хаягийн мэдээллийн санд оруулахгүй байх зэрэг нийтлэг зөрчил их байгаатай холбогдуулан хаягийн мэдээлэл шалгах, засварлах ажлын төлөвлөгөөний дагуу удирдамж гарган дараах ажлыг зохион байгууллаа.

2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрөөс 01 дүгээр сарын 15-ны өдрийн хооронд Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын байранд Алдархаан, Эрдэнэхайрхан, Ургамал, Сантмаргаз, Дөрвөлжин, Завханмандал, Яруу, Отгон, Цагаанчулуут, Цагаанхайрхан сумдуудын хаягийн зураг, мэдээллийн сангийн шинэчлэлт дутууг гүйцээх, тусгай барилга, байгууламжууд хаягжуулах, замчлах ажлыг хийж гүйцэтгэлээ

Аймгийн онцгой комисст ирсэн мэдээллийн дагуу Идэр сумаас баруун урд зүгт 16 км зайд 4.5-4.7 магнитутын газар хөдөлж Идэр сумын барилга байгууламжид үзлэг хийх ажлын хэсэг газар дээр очиж ажилласан.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Аймгийн ГХБХБГ, Аймгийн МХГ, Аймгийн ЗДТГ, Онцгой байдлын газар, БОАЖГ-ын холбогдох хүмүүс оролцсон.

Сумын ЗДТГ, Эрүүл мэндийн төв, сургуулийн 3 хичээлийн байр, спорт заалны барилга, халаалтын зуух, шинээр баригдаж байгаа 320 хүүхдийн хичээлийн байр спорт заалны барилга, 200 хүний суудалтай соёлын төвийн барилга зэрэг 6 барилга байгууламж дээр үзлэг шалгалт хийлээ.

ЗДТГ-ын барилга нь 2012 онд ашиглалтанд орсон ашиглалтын хугацаанд их болон урсгал засвар хийгдээгүй. Газар хөдлөн чичирхийлэлийн улмаас үндсэн хийцэд нөлөөлөхгүй хагарлууд үүссэн гэж үзэж байна. Мөн цонхон дээр хагарал үүссэн байна.

Сургуулийн байр, заал насжилт өндөртэй. Заалны цонхны хамгаалалт чичирхийллээс болоод үүссэн гэж үзэхгүй байгаа. Аливаа барилга байгууламжийг барихад газар хөдлөлтийн чичирхийллээс хамгаалах хамгаалалтууд сүүлийн үеийн барилга байгууламжид 8 баллын чичирхийллийг тэсвэрлэх барилга зураг төслийн дагуу хийгдэж байгаа.

Эмнэлгийн барилга нь нимгэн хагарлууд үүссэн, эмульс унасан байна гэхдээ ноцтой цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй нөхцөл байдал үүсээгүй гэж үзэж байна.

Халаалтын зуухны яндангийн суурь, цонхонд хагарал үүссэн байна. Дотор нь даралтат сав ажиллаж байгаа учраас чичирхийлэлтийг сайн мэдэрдэг. Зуухны тоног төхөөрөмжид эвдрэл гэмтэл үүсээгүй.

Шинээр баригдаж байгаа 2 барилгад ямар нэгэн ан цав, хагарал үүссэн шинж тэмдэг илрээгүй байсан.

2021 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар батлагдсан 21-р зуун жижиг хорооллын гадна дулаан цэвэр бохир усны шугам сүлжээний ажлын зураг төсөв бэлэн болгох, Улиастай хотын инженерийн барилга байгууламжийн судалгаа, техник, эдийн засгийн үндэслэл болосвруулах ажлын саналд шинээр баригдах дулааны станцын ариутгах татуурын шугам сүлжээ, Товцог багт халаалт цэвэр усны шугам сүлжээ, Үйлдвэрийн районы насос станц бохир усны шугам сүлжээ, Жаргалант, Чигэстэй багт 5 км үерийн далан байгуулах, 21-р зуун хорооллын гадна холбооны шугам сүлжээ, Жинст, Богдын гол багт гэр хорооллын дахин төлөвлөлт цэвэр бохир ус, халаалтын шугам сүлжээний ажлын зураг төсөл хийлгэх саналаа БХБЯ-нд хүргүүлсэн.

Мөн 2021 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр зураг төсөл хийлгэх Баянхайрхан сумын ЭМТ-ийн барилга, Их-Уул сумын сургуулийн дотуур байрны барилга, Түдэвтэй сумын цэцэрлэгийн барилгын зураг төсөл боловсруулах зургийн даалгавар, цэвэр бохир дулаан, цахилгаан холбооны техникийн нөхцөл бусад бичиг баримтыг бүрдүүлэн геологи хийх ажлын тендерийг зарлууллаа.

2020 онд шинээр эхлэн, он дамжин баригдаж байгаа БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа хичээлийн байрны барилга-4, цэцэрлэг-5, спорт заал-1, дотуур байрын барилга-1 зэрэг 11 барилга байгууламжийн магадлалын нэгдсэн дүгнэлт, Насан туршын боловсролын төвийн барилгын зураг төслийг хувиан u99701118@gmail.com хаягаар хүргүүлсэн.

Тосонцэнгэл сумын газар доорхи инженерийн шугам сүлжээнд зураглал, хэмжилт хийн мэдээллийн санд оруулах баяжилт хийх ажлыг зохион байгуулан ажилласан.

Улиастай суманд шинээр баригдаж байгаа орон сууцны барилгын судалгаа, 24 сумын инженерийн дэд бүтцийн судалгаа, барилгын салбарт ашиглаж байгаа түгээмэл тархацтай ашигт малтмалын судалгаа, барилгын материалын лабораторид

2020 онд хийсэн ажлын тайланг тус тус гарган Барилгын хөгжлийн төвд, Ерөнхий архитекторын тайланг ГЗБГЗЗГ-т хүргүүллээ.

ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР